


МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ



САНХҮҮГИЙН ЛУЙВАР

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олсон орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулж, хэлбэр дүрсийг нь хувирган эдийн засгийн эргэлтэд оруулж, улмаар “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны орлого мэт харагдуулах оролдлого нь мөнгө угаах гэмт хэрэг юм.




САНХҮҮГИЙН ЛУЙВАР ГЭЖ ЮУ ВЭ?

Банк, санхүүгийн байгууллагын цахим сүлжээнд хууль бусаар нэвтрэх, гэрээний зүйл заалтаар дамжуулах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх замаар, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сайтыг санхүүжүүлэх гэх мэт хэлбэрүүдээр илэрдэг.



Цахим луйвар, залилан



Технологийн хөгжлөөс хамааран сүүлийн жилүүдэд цахим залилан, санхүүгийн гэмт хэрэг нэмэгдэж байна.

Цахим гэмт хэрэг нь аливаа этгээдийн хувийн санхүүгийн мэдээллийг цахим халдлагаар авах, эсвэл цахим мөнгө, токен, виртуал хөрөнгө санал болгох замаар тухайн иргэнийг эд хөрөнгөөр хохироож буй үйлдэл юм.

САНХҮҮГИЙН ЛУЙВРЫН НИЙТЛЭГ ТӨРЛҮҮД

ПИРАМИД СХЕМ

- ❗ Богино хугацаанд өндөр өгөөж амладаг
- ❗ Шинээр гишүүн элсүүлэх замаар үйлдэгддэг
- ❗ Шинээр элсэгчдээс элсэлтийн хураамж авч, дээд түвшний гишүүдэд ашиг болон очдог
- ❗ Хууль, эрх зүйн баримт бичиггүй



Тайлбар:

- Пирамид схемийг үндэслэгч пирамидын дээд хэсэгт байрлах ба доороо 10 гишүүн элсүүлнэ.
- Тус 10 гишүүн нь пирамид схемийг үндэслэгчид тодорхой төлбөр төлж, доороо тус бүр 10 гишүүн ахин элсүүлнэ.
- Эдгээр 100 шинэ элсэгч бүр хоёр дахь шатны гишүүдэд төлбөр төлөх бөгөөд хоёр дахь шатны гишүүд нь орлогынхоо тодорхой хувийг пирамид схемийг үндэслэгч рүү шилжүүлнэ.
- Энэхүү шинэ гишүүн элсүүлэх болон төлбөр төлөх процесс нь удаан хугацааны турш үргэлжилснээр пирамидын дээд түвшний гишүүд их хэмжээний ашиг олох юм.
- Пирамид схем өргөжих тусам шинээр гишүүн элсүүлэх боломжгүй болж, схем нурдаг бөгөөд гишүүдэд хөрөнгөөрөө хохирдог.

Бодит жишээ:




Irish Liberty/Speedball scheme

Ирланд улсад 2000-аад оны дунд үед үйлдэгдсэн энэ схем нь иргэдийг Герман дахь төв компани руу 10,000 еврогоор хөрөнгө оруулаад шинээр хөрөнгө оруулагч урьж оролцуулсан тохиолдолд 80,000 еврогийн ашиг хүртэх боломжтой гэж итгүүлсэн. Тус схемийг бий болгосон этгээд нь 28 сая ам.долларыг завшин зугтаасан байна.

ПОНЗИ СХЕМ

- ! Бага эрсдэлтэй, эсхүл эрсдэлгүйгээр өндөр өгөөж амладаг.
- ! Хуучин хөрөнгө оруулагчдын ашгийг шинэ хөрөнгө оруулагчдаас татсан мөнгөөр төлөх замаар ажилладаг
- ! Зах зээлээс үл хамааран тогтмол өгөөжтэй
- ! Үнэт цаасны бирж, зохицуулагч байгууллагуудад бүртгэлгүй



Тайлбар:

- Понзи схемийг үүсгэн байгуулагч эхний 2 хөрөнгө оруулагчаас 100 төгрөг авна. Анх оруулсан хөрөнгийг сарын дараа 10 хувийн хүүтэй буцаан төлөхөөр амлана.
- Залилагч 200 төгрөгийг хүүтэй нь буцааж төлөхийн тулд 3 хөрөнгө оруулагч олох хэрэгтэй болно. 3 хөрөнгө оруулагчаас авсан 300 төгрөгөөр эхний 2 хөрөнгө оруулагчийн 220 төгрөгийг буцааж төлөөд дахин хөрөнгө оруулалт хийхийг зөвлөнө.
- Шинэ хөрөнгө оруулагчдын мөнгийг авч хуучин хөрөнгө оруулагчдад амласан өгөөжийг өгч, дахин хөрөнгө оруулалт хийхийг ятгаж, олон хүн хамруулахыг санал болгоно.

Пирамид болон Понзи схем нь юугаараа ялгаатай вэ?



Пирамид схем нь хохирогчид тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах, шинээр гишүүд элсүүлэх замаар цалин эсхүл ашиг олох боломжийг санал болгодог.



Понзи схем нь хохирогчид аливаа үйл ажиллагаа эсхүл, бизнест хөрөнгө оруулж, тодорхой хугацааны дараа өгөөж, ашиг хүртэх боломжийг санал болгодог.

PUMP & DUMP СХЕМ

- ! Хямд үнээр худалдаж авсан хувьцаагаа өндөр үнээр худалдах зорилгоор худал, төөрөгдүүлсэн эерэг мэдэгдлийг тарааж, хувьцааны үнийг зохиомлоор өсгөдөг.
- ! Зохицуулалт багатай цахим сүлжээгээр мэдээлэл түгээдэг. /Telegram, Discord гэх мэт/
- ! Хүмүүсийн итгэлийг олохын тулд олны танил хүмүүсийг оролцуулдаг.
- ! Хувьцааны үнэ өссөний дараа хувьцаагаа өндөр үнээр зардаг.



УРЬДЧИЛСАН ШИМТГЭЛ, ХУРААМЖИЙН ЗАЛИЛАН

Гэмт этгээд нь тодорхой бүтээгдэхүүн үйлчилгээг хөнгөлөлттэйгөөр, эсхүл таатай нөхцөлөөр авах боломжийг санал болгодог бөгөөд тухайн үйлчилгээг авахад шаардлагатай тодорхой хэмжээний шимтгэл, хураамжийг урьдчилан төлөхийг шаарддаг. Хохирогч шаардсан урьдчилгаа төлбөр, шимтгэлийг төлсөн хэдий ч тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг авч чаддаггүй.



Жишээ нь:

Хөнгөлөлттэй бизнесийн болон орон сууцны зээл, эсхүл хөрөнгө оруулалт авах боломжтой гэж мэдээлэн, холбогдох мэдээлэл, материалыг бүрдүүлж авдаг. Зээлийн хүсэлтийг хянаж, олгохоор шийдвэрлэсэн тухайгаа мэдэгдэхдээ зээлийн шимтгэл 5 хувь гэх мэт тодорхой хэмжээний төлбөр нэхэмжилдэг.



Бодит жишээ:

ДЭЛХИЙН ХАМГИЙН ТОМ САНХҮҮГИЙН ЛУЙВРЫН ХЭРЭГ /ПОНЗИ СХЕМ/

Үүсгэн байгуулагч

Берни Мэдофф

Уолл-стритийн ахмад зүтгэлтэн, NASDAQ-ын дарга асан Мэдофф түүхэн дэх дэлхийн хамгийн том Понзи схемийг удирдсан.

Тэрээр өөрийн эрсдэлийн сангаар дамжуулан хөрөнгө оруулагчдыг мэхэлж, зах зээлээс үл хамааран хоёр оронтой тоогоор өгөөж өгнө гэж амласан.

Бодит байдал: Хөрөнгө оруулагчийн мөнгийг банкны дансанд байршуулж, үйлчлүүлэгчийг мөнгөө авахыг хүссэн үед шинэ хөрөнгө оруулагчаас хөрөнгө татан төвлөрүүлж, хуучин гишүүдэд шилжүүлдэг байв.

Хэрхэн дууссан

2008 оны санхүүгийн хямралын үеэр тус Понзи схем үргэлжлэх боломжгүй болсон.

Ял шийтгэл

2009 онд 150 жилийн ял авсан ба схемийн хохирогчдод нийт 170 тэрбум долларын нөхөн төлбөрийг олгох үүргийг хүлээсэн.



2008

МЭДОФФИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДУУЛИАН

ЖИЛИЙН ДУНДАЖ ӨГӨӨЖ

S&P 500 (1990-1999)

16%

МЭДОФФ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

10-20%

КРИПТОВАЛЮТЫН ЛУЙВРЫН СХЕМИЙН ТӨРЛҮҮД

1

Биткойны хөрөнгө оруулалтын луйвар

Схемийг ашиглагчид өөрсдийгөө туршлагатай "хөрөнгө оруулалтын менежер" гэж итгүүлэн хуурамч ашгийн баталгаа гаргаж, хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшлийг олж авна.



2

Rug Pull луйвар

Санхүүжилт татахын тулд хуурамч койн, NFT гаргаж хөрөнгө оруулагчдын мөнгийг залилах замаар ажиллана.

3

Romance луйвар

Ихэвчлэн холын зай, цахим харилцаатай холбоотой байдаг бөгөөд нэг тал нөгөө талын итгэлийг олж авснаар криптовалют худалдан авах эсвэл худалдахыг ятгаж эхэлдэг.



4

Phishing луйвар

Криптовалютын хэтэвчний болон хувийн мэдээллийг олж авахын тулд хууль ёсны эх сурвалжаас илгээсэн мэтээр хортой и-мэйл эсвэл мессеж илгээдэг

5 Man-in-the-middle халдлага

Олон нийтийн газар олон нийтийн wifi сүлжээ, hotspot зэргээр дамжуулан криптовалютын данс руу нэвтрэх үед хувийн мэдээлэл, нууц үг, хэтэвчний түлхүүр, дансны мэдээлэл зэргийг хулгайлан авч ажилладаг кибер халдлага юм.



6 Криптовалют бэлэглэх залилан

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр криптовалютуудад бэлэг өгнө гэх мэдэгдлийн дагуу хуурамч сайт руу орж дансны баталгаажуулалт хийснээр өөрийн хувийн мэдээллээ алдаж, криптовалютуудад залилуулдаг.

7 Цахим понзи схем

Уламжлалт понзи схемийн зарчмаар хэрэгжих боловч үйл ажиллагаагаа цахим хуудас, олон улсын крипто бирж гэх мэт цахим хэрэгслийг ашиглан үйлддэг.



8 Хуурамч криптовалютын солилцоо

Нэмэлт урамшуулалт койн шилжүүлэх зэрэг амлалтуудыг өгч, хууран мэхлэх замаар криптовалютыг авч залилах замаар ажиллана.

9 Хөдөлмөр эрхлэлтийн залилан

Хэрэглэгчдийн криптовалютын данс руу нэвтрэхийн тулд виртуал хөрөнгөтэй холбоотой төслийг эрэлхийлж, ажил хайгчийн дүр эсгэнэ.



СҮҮЛИЙН ЖИЛҮҮДЭД ТҮГЭЭМЭЛ ГАРАХ БОЛСОН КРИПТОВАЛҮТЫН ЛУЙВРУУД

RUG PULL ЛУЙВАР

Энэхүү луйврын тод жишээ бол Netflix-ийн алдартай Squid Game цувралын нэрээр нэрлэгдсэн “SQUID” койн байв.

Төслийн багийнхан бүх токеноо борлуулсны дараа төслийг дуусгасан ба “SQUID” койны ханш 99,99 хувиар буурч үнэ цэнээ алдсан байна. Ингэснээр койны хөөсрөл явагдаж, дэлхий дахинд олон зуун иргэн хохирчээ.



PHISHING/ ФИШИНГ ЛУЙВАР

Луйварчид криптовалютын хувийн болон хэтэвчний мэдээллийг олж авахын тулд ихэвчлэн бирж зэрэг хууль ёсны эх сурвалжаас илгээж байгаа мэтээр хохирогчид руу хортой и-мэйл эсвэл мессеж илгээдэг. Гэвч энэ нь хуурамч вэбсайт руу хөтөлдөг ба хохирогч холбоос дээр дарж, нэвтрэх мэдээллээ оруулснаар тус луйварт өртдөг.

Энэ төрлийн луйврын том жишээ бол Японы алдартай Coincheck бирж юм. Хакерууд фишинг луйврыг ашиглан мессеж илгээж хэрэглэгчдийн хэтэвчинд халдаж, их хэмжээний хохирлыг учруулж байв.



Бодит жишээ:

БИТКОЙН: ПОНЗИ СХЕМ

Үүсгэн байгуулагч

Трендон Шиверс


Bitcoin Savings and Trust (BCS&T) компанийн үүсгэн байгуулагч ба интернетээр дамжуулан биткойн дээр суурилсан хөрөнгө оруулалтыг санал болгож, борлуулдаг байсан..

Шиверсийн хөрөнгө оруулагчдад тавьсан санал:

BCS&T-д хөрөнгө оруулагчид биткойныг 7 хоногт 7%-ийн хүүтэй зээлдүүлэх боломжтой. Түүнчлэн, хөрөнгө оруулагчид хүссэн үедээ хөрөнгө оруулалтаа эргүүлэн татах ба зах зээлийн хэлбэлзэлтэй холбоотой аливаа алдагдлыг нөхөх баталгаа гаргаж өгнө.

Бодит байдал:

Шинэ хөрөнгө оруулагчдаас авсан биткойноор хуучин хөрөнгө оруулагчдад хүүгийн төлбөр хийдэг байсан.



ПОНЗИ СХЕМЭЭР ЗАЛИЛСАН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ:

2016 он



146,000
БИТКОЙН
=
\$807,380

САНХҮҮГИЙН ЛУЙВРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМУУД

1

Тухайн үйл ажиллагааг явуулах зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлтэй, найдвартай эсэхийг шалгах



2

Хөрөнгө оруулалт хийж буй компанийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх /үүсгэн байгуулагчдын туршлага гэх мэт/

3

Эрсдэл багатай эсвэл эрсдэлгүйгээр их хэмжээний эсвэл шууд өгөөжтэй хөрөнгө оруулалт санал болговол тухайн хөрөнгө оруулалтын талаар сайтар судалж, шаардлагатай баримт материалуудтай танилцсаны үндсэн дээр шийдвэр гаргах



4

Тухайн компани тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, тодорхой ажлын байртай эсэхийг нягтлах

5

Нэмэлт асуулт асууж, хэрхэн оновчтой хариулт өгч байгаа эсэхийг нягтлах



6

Одоо л хөрөнгө оруулалт хийхгүй бол боломжийг алдана гэх мэт яаруулсан шинж ажиглагдвал ахин бодолцож үзээрэй.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХАРИУЦЛАГА

Санхүүгийн луйврыг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд зааснаар зохицуулдаг. Үүнд:

1. Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг:
 - 2.1. албан тушаалын байдлаа ашиглаж;
 - 2.2. бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийг:
 - 3.1. байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;
 - 3.2. олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн;
 - 3.3. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



АНХААРУУЛГА

Санхүүгийн мэдлэг дутмаг байдал болон богино хугацаанд их ашиг олох хүслийн үр дүнд олон иргэд хөрөнгө мөнгөөрөө хохирч байна. Жишээ нь сүүлийн үед криптовалютын луйвар, сүлжээ, аппликейшн зэргээр дамжуулан мөнгөө өсгөх гэх мэт луйврын олон төрлийн арга хэрэгсэл бий болсон.

Санхүүгийн пирамид болон понзи схемийн луйвар нь байнга хувьсан өөрчлөгдөж, үйл ажиллагаагаа өнгөлөн далдалж, аажим томруулдаг тул илрүүлэхэд хүндрэлтэй, ихээхэн цаг хугацаа шаардагддаг.

Манай улсад залилан, сүлжээний луйврын гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага, хууль эрх зүйн зохицуулалт байгаа боловч энэ төрлийн залилангийн хэрэг жил ирэх тусам нэмэгдэж, хохирогчдын тоо болон мөнгөн дүн өсөж байгааг хуулийн байгууллагын албан ёсны мэдээллээс харж болно.

Иймд иргэд санхүүгийн мэдлэг боловсролоо дээшлүүлж, богино хугацаанд өндөр хүү, ашиг амласан санхүүгийн луйварт итгэж хөрөнгө оруулалт хийхгүй байх, тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн этгээдээс санхүүгийн үйлчилгээ авч, баталгаатай хөрөнгө оруулалтын хэрэгслийг сонгох шаардлагатай. Ингэснээр өөрийгөө болон бусдыг санхүүгийн луйврын хохирогч болохоос сэргийлэх боломжтой юм.



Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот,
15160